



MBR AUDIT
АУДИТ, БАТАЛГААГУУЛАГ,
ХАРААГИЙН ҮЙСЭГЭЭ

Г АЛБАН ЖУРМЫН 7
ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ
УДИРДАХ ЗӨВЛӨЛД

МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ

ХХК Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
"Барилга МН" ХХК-ний оффис, 3-р давхар, 303 тоот

Tel: (+976) – 70008329, (+976) – 99851823
Mail: mbr.audit.fo@gmail.com

2017.02.14 № 02/020

тантай-ны №-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн тухай

Бид "Албан журмын даатгагчдын холбоо" ТББ-ийн (шашид ТББ гэх)-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хавсаргасан Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй ба бусад тайлбар мэдээллүүдэд аудит хийлтээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол Улсын хууль болон даатгалын багц дүрмийн дагуу бэлтгэж, шударгаар толилуулах, санхүүгийн тайлангуудыг алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэх боломж бүрдүүлэхэд шаардагдах дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээдэг.

Аудиторын үүрэг хариуцлага

Гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй баталгаа олж авахын тулд ёс зүйн шаардлагыг баримтлан, аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шалгадаг.

Аудит нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаарх аудитын нотолгоо олж авах зориулалтаар гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгож авсан горимууд нь аудиторын үнэлэмжээс хамаарах бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ багтдаг. Эрсдэлийн энэхүү үнэлгээг хийхдээ аудитор байгууллагын дотоод хяналтын үр ашигт байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг зохиох зорилготойгоор аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллуудын үл үндэслэлтэй байдал, хэрэглэсэн бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг өөртөө агуулдаг.

Аудитын үр дүнд Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан ажилтанд 45,000.0 мянган төгрөгийн илүү тэтгэмж олгох, Удирдах зөвлөлийн тогтоолыг зөрчиж, үндэслэлгүйгээр нэр бүхий албан тушаалтануудад 7,600.0 мянган төгрөгийн илүү цалин олгох, хууль бус шийдвэр гаргаж ажлаас халагдсан ажилтануудад шүүхийн

шийдвэрээр 42,019.7 мянган төгрөгийн нөхөн олговор олгох, Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалтыг зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 37,000.0 мянган төгрөг, Жолоочийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад хугацаатай байршуулсан хадгаламжийг хугацаанаас нь өмнө цуцалж, хуульд заасан шалгуур хангаагүй банканд хүүг бууруулж байршуулснаар 134,176.5 мянган төгрөг, ажлтан нарт олгосон хоол, унааны хөнгөлөлтөд 511.4 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу ногдуулсан зэргээс жолоочийн даатгалын санд нийт 256,307.6 мянган төгрөгийн хохирол учруулсан алдаа зөрчлүүд илэрч байна.

Бид аудитын дүгнэлтийн үндэслэл болохуйц зохистой бөгөөд хангалттай аудитын нотолгоог олж авсан гэж найдаж байна.

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээрх зөрчлийг эс тооцвол “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Монгол Улсын хууль, жолоочийн даатгалын багц дүрэм, журмын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.1-р зүйлд заасан хэрэглэгчид болох “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-ийн Удирдах зөвлөл болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



“Монголын Бизнес Рейтинг Аудит” ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2017-07-08

Тусгай зөвшөөрөл: 135-2014

ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж болон зохицуулалтын бусад эрх зүйн шийдвэрүүдийн хэрэгжилтийн талаар

Бид “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу, Аудиторууд бид “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль, албан журмын даатгагчдын холбоотой холбогдох тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийн байдлыг авч үзсэн.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцадаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор тус холбоонд мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын мөрдөлтийн талаар сорил гүйцэтгэсэн бөгөөд доорх зүйлтээс бусад зүйлсийн хувьд Монгол Улсын хууль тогтоомж, жолоочийн даатгалын сангийн заавар журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

- “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ нь Жолоочийн даатгалын тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- o Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалтыг зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах
- o Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.1-д “Холбоо нь сангийн данс байршуулах, орлого төвлөрүүлэх бэлэн мөнгөний төлбөр тооцоог... банкыг сонгон шалгаруулна”, 3.2.1-д “Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар хангасан”, 3.3-д “...сонгон шалгаруулалтад шалгарсан харилцагч банктай гэрээ байгуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн
- o Байгууллагын “Хөдөлмөрийн дотод журам”-ын 9.9 дахь заалтыг санаатай өөрчилж, Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.1-д “талууд харилцан тохирсон” гэсэн заалтаар хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан ажилтанд тэтгэмж олгох.
- o Удирдах зөвлөлийн тогтоолыг зөрчиж, үндэслэлгүйгээр нэр бүхий албан тушаалтануудад илүү цалин олгох

Холбооны гүйцэтгэх урирлага эдгээр хууль эрх зүйн шийдвэрүүд зөрчигдсэн талаар УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, залруулах-шийдвэрүүдийг гаргуулсан байна.


“Монголын Бизнес Рейтинг Аудит” ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2017-07-08
Тусгай зөвшөөрөл: 135-2014

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ТББ
 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил
 САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодот гол	2015.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө		-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		195,188,662.17	70,134,639.56
Богино хугацаат хөрөнгө оруулалт		5,199,992,714.47	6,954,668,629.83
Авлага		1,355,770,540.02	2,209,143,661.55
Бараа материал		14,274,408.00	16,184,669.00
Урьдчилж төлсөн зардал/гооцоо		7,428,234.00	5,257,040.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		6,772,654,558.66	9,255,388,639.94
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө		642,839,494.63	528,502,563.14
Биет бус хөрөнгө		62,886,575.34	191,503,242.01
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		705,726,069.97	720,005,805.14
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		7,478,380,628.63	9,975,394,445.08
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Богино хугацаат өглөг		-	-
Дансны өглөг		90,200.00	8,108,017.32
Цалингийн өглөг		105,630.52	472,937.79
Татвар хураамжын өр		159,000.00	71,443.79
Бусад өглөг		257,145.00	238,774.00
Урьдчилж орсон орлого			1,000,000.00
Богино хугацаат өглөгийн дүн		611,975.52	9,891,172.90
Өр төлбөрийн дүн		611,975.52	9,891,172.90
Цэвэр хөрөнгө:			
Нөөц: а) Хязгаарлалтгүй		-	10,000,000.00
б) Хязгаарлалттай		10,000,000.00	9,937,760,891.20
Хуримтлагдсан үр дүн		7,467,768,653.11	-
Тайланг үеийн		-	17,742,380.98
Өмнөх үеийн		7,477,768,653.11	-
Эздийн өмчийн дүн		7,477,768,653.11	9,965,503,272.18
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН		7,478,380,628.63	9,975,394,445.08

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ТББ
2016 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тэмдэглэл	2015.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны орлого	13	2,727,466,562.66	3,935,599,227.85
Үндсэн үйл ажиллагааны зардал	12	1,154,778,680.38	1,448,043,384.78
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		1,572,687,882.28	2,487,555,843.07
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		-82,500.00	178,776.00
Үндсэн бус үйл ажиллагааны (алдагдал)		-82,500.00	178,776.00
Тайлант үеийн цэвэр үр дүн		1,572,605,382.28	2,487,734,619.07

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ТББ
 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил
 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөг)

	Хязгаарлалт гүй нөөц	Хязгаарлалт тай нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00		4,673,379,322.68	4,683,379,322.68
НБББ-ын өөрчлөлтийн нөлөөлөл, алдааны залруулга			128,043,755.56	128,043,755.56
Залруулсан үлдэгдэл	10,000,000.00		4,801,423,078.24	4,811,423,078.24
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,666,345,574.87	2,666,345,574.87
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00		7,467,768,653.11	7,477,768,653.11
НБББ-ын өөрчлөлтийн нөлөөлөл, алдааны залруулга		7,467,768,653.11	-7,467,768,653.11	-
Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	7,467,768,653.11	-7,467,768,653.11	-
Тайлант үеийн үр дүн (алдагдал)		2,469,992,238.09	17,742,380.98	2,487,734,619.07
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00	9,937,760,891.20	17,742,380.98	9,965,503,272.18

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ТББ
 2016 он 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил
 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,209,843,573.58	2,744,405,632.54
Гишүүдийн татвараас орсон мөнгө	15,000,000.00	14,000,000.00
Даатгалын сангийн орлого	2,160,664,563.46	2,467,646,028.91
Бусад мөнгөн орлого	34,179,010.12	262,759,603.63
Мөнгөн зарлагын дүн (-)	1,133,786,226.72	1,469,919,625.73
Ажилчдад төлсөн	560,787,308.10	596,377,059.79
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	116,595,651.24	139,389,448.48
Бараа материал худалдан авахад төлсөн	57,044,868.00	14,086,179.00
Ашиглалтын зардалд төлсөн	215,455,234.00	233,054,522.12
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	31,374,790.00	35,393,922.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	156,419,713.80	230,055,683.15
Татварын байгууллагад төлсөн	49,660,008.94	64,433,271.19
Даатгалын төлбөрт төлсөн	6,957,744.00	157,129,540.00
Бусад мөнгөн зарлага	-	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,517,333,915.00)	(1,918,232,415.36)
Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө		(163,556,500.00)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(1,517,333,915.00)	(1,754,675,915.36)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(1,918,232,415.36)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		518,692,385.94
Банкнаас авсан зээл /НТ-ийн төлөлт/	94,098,424.00	-
Зээлийн төлөлт /НТ-ийн олголт/	111,287,484.00	-
Хүү ба урамшуулалын орлого	631,008,292.90	518,692,385.94
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	611,926,152.90	518,692,385.94
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	110,140,493.70	(125,054,022.61)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	85,048,168.47	195,188,662.17
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	195,188,662.17	70,134,639.56

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.